



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/113/СТА-ТШЗ

Баянхонгор хот. 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 7044-2584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 7044-2424 Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 2/123

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

2519232

Аудитаар Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Н.Мэндбаярт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.23-наас 2019.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа, аудитор П.Мөнх-Эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь Гэр бүл, хүүхэд, залуучуудад ээлтэй бодлого хэрэгжүүлж тэднийг хөгжих таатай орчин бий болгох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гэр бүл, хүүхдийг хамгаалах
- Залуучуудыг дэмжих

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Acolous 4.01" програм хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт дунд гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 557677,6 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 11153,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн ба санхүүгийн тайланд залруулга хийлгээгүй болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	150.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	150.00	

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 328247,0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 327872,3 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь тогтмол зардлын төлөвлөлт үндэслэл муутайгаас зарим зардал хэтэрч, хэтрэлтийг хэмнэгдсэн зардлаас гүйлгэж, тогтмол зардлын дүнгээр 257,9 мянган төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой.

Өөрийн орлогын төлөвлөгөө байхгүй. Байгууллагын харьяанд байдаг Өвгөнжаргалант хүүхдийн зуслангийн орлогоор 39455,0 мянга, ажилтнуудын шинжээчээр ажилласны зардалд 930,0 мянган төгрөг төвлөрсөн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.1.1 Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг буруу гаргаж ирүүлсэн.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 08 тоот тушаалаар батлагдсан зааврыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын тушаалаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх зааврын дагуу тайланг үнэн зөв гаргах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна. Хэрэгжүүлж ажиллана.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын ажлын хэсэгт нярвыг оролцуулсан бөгөөд тооллого хийх хугацааг тодорхой тусгаагүй, тооллогын бүртгэлд үндэслэн тооцоо бодсон акт гаргаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар заалтыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Тооллого, тооцоог цаг хугацаанд нь хийгээгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар заалтын дагуу тооллогын комиссыг байгуулж, тооллогын дүнг хэлэлцэж, тэмдэглэл хөтөлж, тооцоо бодсон актаар баталгаажуулж байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна. Хэрэгжүүлж ажиллана.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Оны эхэнд үлдэгдлээр байсан 150,0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, байгууллагуудтай батлагдсан маягтаар тооцоо нийлсэн акт үйлдээгүй.

Энэ нь Үнэн зөв байдал, оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Өмнөх оны авлагыг холбогдох буруутай ажилтнаар төлж барагдуулах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна. Хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 01-ний дотор албан бичгээр ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,989,529.19</u>	<u>38,709,342.19</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.01	00.01
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.01	00.01
3121	Төгрөг	00.01	00.01
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.01	00.01
33	АВЛАГА	643,637.00	169,040.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	188,552.00	150,000.00
335	Бусад авлага	455,085.00	19,040.00
3351	Байгууллагаас авах авлага	116,087.00	19,040.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	338,998.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	11,345,892.18	38,540,302.18
351	Түүхий эд материал	00.00	1,991,000.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	1,991,000.00
354	Хангамжийн материал	11,345,892.18	36,549,302.18
35410	Бичиг хэргийн материал	3,655,689.00	3,362,099.00
35420	Аж ахуйн материал	5,611,203.18	5,376,203.18
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	63,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,079,000.00	27,748,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>88,206,347.33</u>	<u>289,996,582.55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	88,206,347.33	289,996,582.55
392	Биет хөрөнгө	88,127,597.44	236,402,832.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	168,764,403.00	173,103,726.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	-159,035,607.06	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,000,000.00	21,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-13,469,240.00	-15,569,240.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	78,712,453.00	78,712,453.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-50,586,071.45	-60,242,264.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,211,781.45	63,011,781.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,635,088.50	-26,578,590.65
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,949,550.00	3,749,550.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,949,550.00	-1,949,550.00
39217	Ном	1,164,967.00	1,164,967.00
393	Биет бус хөрөнгө	78,749.89	53,593,749.85
39301	Програм хангамж	625,000.00	625,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-546,250.11	-581,250.15
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	53,550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>100,195,876.52</u>	<u>328,705,924.74</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>100,195,876.52</u>	<u>328,705,924.74</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	100,195,876.52	328,705,924.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	41,168,933.00	94,718,933.00
51101	Өмч: - төрийн	41,168,933.00	94,718,933.00
512	Хуримтлагдсан үр дүн	56,246,358.02	67,076,495.23
51210	Өмнөх үеийн үр дүн	56,246,358.02	56,246,358.02
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	10,830,137.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,780,585.50	166,910,496.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>100,195,876.52</u>	<u>328,705,924.74</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	635,726,593.00	568,507,781.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,264,500.00	43,385,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	25,264,500.00	43,385,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,264,500.00	43,385,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,264,500.00	40,385,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	3,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	465,019,793.00	196,875,781.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	145,442,300.00	328,247,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	376,861,438.00	193,364,940.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	376,861,438.00	193,364,940.00
1330	Төсвийн захирагчдаас	82,040,786.00	00.00
133003	Хөрөнгийн	82,040,786.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,117,569.00	3,510,841.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,117,569.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	3,510,841.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	561,058,559.10	557,677,643.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	561,058,559.10	557,677,643.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	525,294,368.30	553,791,120.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,886,825.00	86,443,257.00
210101	Үндсэн цалин	96,886,825.00	86,443,257.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,137,250.00	12,465,595.00
210201	Тэтгэврийн даатгал	6,902,826.00	11,601,188.00
210202	Тэтгэмжийн даатгал	657,022.00	216,101.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	809,278.00	172,881.00
210204	Ажилгүйдлийн даатгал	160,739.00	43,220.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,607,385.00	432,205.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,994,150.00	12,923,014.00
210301	Гэрэл, цахилгаан	1,214,645.00	1,456,527.00
210302	Түлш, халаалт	9,316,395.00	10,490,047.00
210303	Цэвэр, бохир ус	463,110.00	976,440.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,548,085.00	6,838,776.00
210401	Бичиг хэрэг	1,324,730.00	4,139,590.00
210402	Тээвэр, шатахуун	422,700.00	1,394,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,655.00	1,304,926.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,000.00	578,300.00
210604	Урсгал засвар	25,000.00	578,300.00
2107	Томиллолт, зочны зардал	560,000.00	563,700.00
210702	Дотоод албан томиллолт	560,000.00	563,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	388,446,639.00	413,817,803.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	388,446,639.00	413,817,803.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,696,419.30	20,160,675.79
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,733,000.00	1,671,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,963,419.30	18,489,675.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,764,190.80	3,886,523.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,764,190.80	3,510,841.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,117,569.00	3,510,841.00

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,046,621.80	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,600,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	374,723.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	374,723.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	959.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	959.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	74,668,033.90	10,830,137.21
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	74,668,033.90	10,830,137.21

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	553,685,807.00	565,507,781.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,264,500.00	40,385,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	25,264,500.00	40,385,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,264,500.00	40,385,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,264,500.00	40,385,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	528,421,307.00	525,122,781.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	145,442,300.00	328,247,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	376,861,438.00	193,364,940.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	376,861,438.00	193,364,940.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,117,569.00	3,510,841.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,117,569.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	3,510,841.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	553,685,807.00	565,507,781.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	553,685,807.00	565,507,781.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	517,504,010.00	561,621,258.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,532,181.00	93,086,378.00
210101	Үндсэн цалин	97,532,181.00	93,086,378.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,212,558.00	11,181,019.00
210201	Тэтгэврийн даатгал	7,334,097.00	7,852,119.00
210202	Тэтгэмжийн даатгал	385,668.00	832,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	477,260.00	665,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	92,321.00	166,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	923,212.00	1,664,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,994,150.00	12,942,054.00
210301	Гэрэл, цахилгаан	1,214,645.00	1,456,527.00
210302	Түлш, халаалт	9,316,395.00	10,490,047.00
210303	Цэвэр, бохир ус	463,110.00	995,480.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,750,255.00	3,890,726.00
210401	Бичиг хэрэг	3,526,900.00	1,165,400.00
210402	Тээвэр, шатахуун	422,700.00	1,402,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,655.00	1,322,626.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	339,500.00	343,300.00
210604	Урсгал засвар	339,500.00	343,300.00
2107	Томиллот, зочны зардал	560,000.00	563,700.00

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	560,000.00	563,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	390,825,366.00	436,322,381.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	390,825,366.00	436,322,381.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,290,000.00	3,291,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,290,000.00	3,291,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,181,797.00	3,886,523.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,764,190.80	3,510,841.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,117,569.00	3,510,841.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,046,621.80	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,600,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	417,606.20	374,723.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	417,606.20	374,723.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	959.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	959.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.01	00.01
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.01	00.01

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,168,933.00	2,780,585.50	56,246,358.02	100,195,876.52
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,168,933.00	2,780,585.50	56,246,358.02	100,195,876.52
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	164,129,911.01	00.00	164,129,911.01
Тайлант үеийн үр дүн	53,550,000.00	00.00	10,830,137.21	64,380,137.21
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	67,076,495.23	328,705,924.74

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	145,442,300.00	145,360,414.80	328,247,000.00	327,872,277.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145,442,300.00	145,360,414.80	328,247,000.00	327,872,277.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	115,795,600.00	115,713,793.00	328,247,000.00	327,872,277.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	86,847,800.00	86,847,800.00	93,161,600.00	93,086,378.00
210101	Үндсэн цалин	86,847,800.00	86,847,800.00	93,161,600.00	93,086,378.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,948,400.00	8,932,088.00	11,222,500.00	11,181,019.00
210201	Тэтгэврийн даатгал	5,643,637.00	7,053,627.00	7,893,600.00	7,852,119.00
210202	Тэтгэмжийн даатгал	657,360.00	385,668.00	832,200.00	832,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	821,700.00	477,260.00	665,800.00	665,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	165,973.00	92,321.00	166,400.00	166,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,659,730.00	923,212.00	1,664,500.00	1,664,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,996,800.00	10,994,150.00	13,200,000.00	12,942,054.00
210301	Гэрэл, цахилгаан	750,900.00	1,214,645.00	954,100.00	1,456,527.00
210302	Түлш, халаалт	8,993,900.00	9,316,395.00	8,993,900.00	10,490,047.00
210303	Цэвэр, бохир ус	1,252,000.00	463,110.00	3,252,000.00	995,480.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,803,900.00	4,750,255.00	3,890,800.00	3,890,726.00
210401	Бичиг хэрэг	3,893,100.00	3,526,900.00	1,980,000.00	1,165,400.00
210402	Тээвэр, шатахуун	402,700.00	422,700.00	1,402,700.00	1,402,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	508,100.00	800,655.00	508,100.00	1,322,626.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	343,300.00	339,500.00	343,300.00	343,300.00
210604	Урсгал засвар	343,300.00	339,500.00	343,300.00	343,300.00
2107	Томилолт, зочны зардал	563,700.00	560,000.00	563,700.00	563,700.00
210702	Дотоод албан томилолт	563,700.00	560,000.00	563,700.00	563,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	202,573,400.00	202,573,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	202,573,400.00	202,573,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3291700.00	3290000.00	3291700.00	3291700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,291,700.00	3,290,000.00	3,291,700.00	3,291,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29646700.00	29646700.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,646,700.00	29,646,700.00	00.00	00.00

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,046,700.00	26,046,621.00	00.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,600,000.00	3,600,000.00	00.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	145,442,300.00	145,360,414.81	328,247,000.00	327,872,277.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	145,442,300.00	145,360,414.81	328,247,000.00	327,872,277.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	145,442,300.00	145,360,414.81	328,247,000.00	327,872,277.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	15	15	15	15
620001	Удирдах ажилтан	01	01	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	07	07	07	07
620003	Үйлчлэх ажилтан	04	04	04	04
620004	Гэрээт ажилтан	03	03	03	03
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12	12	15	15
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	06	06	06	06
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06	06	06	06
650010	Гэрээт ажилтан	00	00	03	03